

## ТЭМДЭГЛЭЛТ ОЙ

**ХЯТАДЫН АРД ТҮМНИЙ ҮНЭНЧ ХҮҮ ЦЮЙ ЦЮБО****(Мэндэлсний нь 85 жилийн ойд)**

XX зууны эхний хагасын хятадын нийгэм-улс төрийн түүхийн хувьсгалт өрнөлтийг Цюй Цюбогүйгээр төсөөлөхөд бэрх билээ. Олон улсын Коммунист хөдөлгөөний нэрт зүтгэлтэн, ХКН-ын удирдагчдын нэг, марксизм-ленинизмын үзэл санааг гарамгай сурталчлагч Цюй Цюбо 1899 оны 1-р сарын 29-нд Цзянсу мужид ядуу багшийн гэрт төржээ. Цюй Цюбо бага, дунд сургуульд суралцан төгсөөд 1916 онд Бээжинд ирж орос хэлний дээд сургуульд элсэн оржээ.

Октябрийн хувьсгалын үзэл санааны нөлөөгөөр хятадад өрнөсөн 1919 оны империализмын эсрэг «5-р сарын 4-ний хөдөлгөөн»-д оролцсон нь түүний шударга үйлийн төлөө тэмцэх эхлэл болсон юм.

Цюй Цюбогийн улс төрийн хандлагаа сонгон авахад хятадын анхны марксист Ли Дажао хүчтэй нөлөөлсөн бөгөөд улмаар 20-иод оны хавраас Цюй Цюбо Хятад дахь анхны марксист дугуйланд элсэн оржээ. Энэ үеэс эхлэн Цюй Цюбо хэвлэлд цаг үеийн асуудлаар өгүүлэл бичиж нийтлүүлдэг байв.

1920 оны эцсээр залуу сэтгүүлч Цюй Цюбо-г тэр үеийн дэвшилт хэвлэл болох «Чэньбао» (өглөөний сонин) -ы сурвалжлагчаар Зөвлөлт Орос Улс руу томилон явуулсан явдал бол түүнд хүлээлгэсэн их итгэл найдвар байлаа. Цюй Цюбо Октябрийн хувьсгалын мөн чанарыг ойлгоход Ли Дажаотай танилцсан, Зөвлөлт Орос руу явсан энэ хоёр явдал их тус болжээ. 1921—1922 онуудад Москвад ажиллаж амьдарсан нь Цюй Цюбогийн ертөнцийг үзэх марксист үзэл төлөвшин тогтоход болон түүний цаашдын үйл ажиллагаанд нөлөөлсөн шийдвэрлэх хүчин зүйл боллоо. Энд байх хугацаандаа ажилчин, окутан, цэрэг, тариачин зэрэг нийгмийн янз бүрийн давхрааны хүмүүстэй уулзан ярилцаж, дэлхийг донсолгосон аугаа их Октябрийн хувьсгалын мөн чанарыг гүн гүнзгий ухаж ойлгохыг эрмэлзэж байв.

Цюй Цюбо Москвад байхдаа В. И. Ленинтэй уулзаж, 1922 оны 2-р сард ХКН-ын эгнээнд орсон ба улмаар өөрийн бүх ухамсарт амьдралаа хятадын үгээгүй олны хувь заяатай үүрд холбосон юм. Цюй Цюбо Алс Дорнодын ард түмнүүдийн их хурал (1922 он), Коминтерний III, IV хуралд (1921, 1922 он) төлөөлөгчөөр оролцож байв. Тэрээр «Зөвлөлт Оросын тухай», «Шинэ Оросын тухай-замын тэмдэглэл», «В. И. Лениний тухай» зэрэг нийтлэл, өгүүлэл олныг бичсэн юм.

Цюй Цюбо 1925—1927 оны хятадын хувьсгалын эхийг тавьсан 1925 оны «5-р сарын 30»-ны хөдөлгөөний Шанхайн пролетаруудын удирдагчдын нэг байсан бөгөөд тус хотын ажилчдын анхны сонин «Кэсюэ» (Халуун цус)-г редакторлаж байв.

Цюй Цюбо 1923 онд ХКН-ын ТХ-ны гишүүнээр, 1927 онд ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргаар тус тус сонгогдон ажиллаж байсан нь намын дотор түүний нэр хүнд хичнээн өндөр байс-

ныг харуулж байна. Хятадад Марксизм-Ленинизмийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагаанд бүх амьдралаа зориулсан Цюй Цюбо-гийн хувьсгалт тэмцлийн зам шулуун дардан байсангүй. Тэрээр Хятадын тэр үеийн бусад сэхээтнүүдийн нэгэн адил зарим алдаа гаргаж байсан боловч, алдаагаа тэр дор нь ухаарч засч чадсан билээ.

Зөвлөлт Орос Улс дахь Хятадын хэвлэлийн анхны төлөөлөгч Цюй Цюбо нь өөрийн интернационалч үүргээ биелүүлэхээс гадна «Ардчилсан хувьсгал дахь социал-демократын хоёр тактик», «Төр ба хувьсгал», «Зүүний нялхсын өвчин» зэрэг Лениний зохиолуудын орчуулгыг редакторлан, коминтерний программын чанартай баримт бичгүүдийг хятад хэл рүү хөрвүүлж, нийтлэл, судлалын олон арван өгүүлэл туурвин бичжээ.

1930-аад оноос эхлэн хувьсгалт үйл хэргийн үйлсэд үзгээрээ зэвсэг хийж, утга зохиолын ажилд гол анхаарлаа хандуулж, утга зохиол соёлын асуудалд зориулагдсан марксизм-ленинизмийн сонгодог зохиолыг хятад хэлээр орчуулах ажлыг дагнан хийж эхэлжээ. Түүний уран бүтээлийн өв санд утга зохиолын онол болон шүүмж өгүүлэл чухал байр суурь эзэлдэг бөгөөд Хятадын утга зохиол, урлагийн сэхээтнүүдэд марксист гоо зүйн мэдлэгийг анх олгосон хүн бол Цюй Цюбо болно.

Цюй Цюбогийн зохиол бүтээлүүдэд түүний пролетарийн интернационализм, марксист-ленинист зарчимд гуйвшгүй үнэнч бөгөөд ажилчин ангийн дайсантай эвлэршгүй тэмцэгч байсан нь товойн харагддаг юм.

Цюй Цюбо-г хятадын уншигчдыг оросын сонгодог болон зөвлөлтийн утга зохиолтой танилцуулахад их хувь нэмэр оруулсан хүн гэж зүй ёсоор үздэг. 1934 оны 10-р сард Хятадын улаан армийн гол хүч төв штабаа арга буюу орхиход хүрч Цюй Цюбо намын шийдвэрээр нууц байдалд ажлаа үргэлжлүүлэхээр үлдсэн юм. 1935 оны 2-р сард Фуцянь мужид хүнд өвчтэй байсан Цюй Цюбо-г гоминданыхан баривчилсан билээ. Тэд Цогт хувьсгалчийг өөрийн нь үзэл бодлоос ухраах гэж зүсэн бүрээр оролдсон боловч түүний чин зоригийг мохоож чадаагүй юм. Үүндээ хорссон гоминданы харгисууд 1935 оны 6-р сарын 18-нд Хятадын ард түмний үнэнч хүү Цюй Цюбо-г цаазалсан билээ. Тэрээр зандалчдад хандаж: «Би бүх амьдралаа хувьсгалд зориулсан билээ. Нэгэнт би баривчлагдсан болохоор намайг үхэл хүлээж байна. Би хэдийгээр үхсэн ч миний замаар сая сая хүмүүс урагшлах болно» гэж хэлсэн юм. Цюй цаазлагдахаар явахдаа анх өөрөө хятад хэл рүү орчуулсан «Интернационалыг» дуулж явлаа. Түүний цаазлагдсантай холбогдуулан Коминтерний Гүйцэтгэх Хороо «Цюй Цюбо нь бүх орны коммунистуудын сэтгэл зүрхэнд үүрд үлдэнэ» гэж цохон тэмдэглэсэн байдаг.

Цюй Цюбо бол Хятадын хувьсгалын стратеги, тактикийг боловсруулах, ХКН-ын интернационалч чиг шугамын төлөө тэмцэл, хятад зөвлөлтийн ард түмний болон хоёр намын хооронд найрамдлыг бэхжүүлэхэд их хувь нэмэр оруулсан хүн юм. Тийм ч учраас Хятадын түүхэнд уршигт ул мөр үлдээсэн «соёлын хувьсгал» гэгчийн үед маогийнхан Цюй Цюбогийн ариун шарилыг хөндөж, түүний эсрэг гүжир гүтгэлгийн кампани явуулсан бөгөөд энэ нь цогт хувьсгалч, тууштай интернационалчийн нэр сүрийг өчүүхэн ч гутааж чадаагүй юм.

Цюй Цюбо нь Хятадын алдарт зохиолч Лу Синьтай ажил төрлийн холбоотой байсан ба тэдний үзэл бодол утга зохиолын онол, практикийн үндсэн асуудлаар нийцдэг байв.

Цюй Цюбогийн нас нөгчсөний дараа түүний «Далайн чанадаас ирсэн бодлын эмхэтгэл» гэсэн нэртэй орчуулгын хоёр ботийг хэвлүүлэх ажилд Лу Синь их хүч зарцуулж, редакторлан хэвлүүлж чадсан юм.

Лу Синь энэ эмхэтгэлийн тухай хэлэхдээ, «түүний бүтээлийг хэвлүүлснээ би өөрийн эсэргүүцэл, нөхөртөө зориулсан дурсгал гэж үзэж байна. Зохиолчийг нь алсан ч зохиолыг нь алж чадахгүй, түүний зохиол бүтээл нь мөнх юм» гэжээ. Энэ эмхэтгэл гарсан явдал бол хятадын хувьсгалт утга зохиолын орчуулгын түүхэнд чухал үе болон орсон юм.

Их гүрний үндсэрхэг дээрэнгүй үзлийн элдэв илрэлтэй эвлэршгүй тэмцэгч, пролетарийн интернационализмын зарчимд чин үнэнч Цюй Цюбогийн баатарлаг амьдрал нь хятадын ард түмэнд үлгэр дууриалал болсон юм. Хятадын ард түмний үнэнч хүү, интернационалч, коммунист Цюй Цюбо-гийн төрсний 85 жилийн ойг Монголын ард түмэн дэлхийн дэвшилт олон түмний хамт хүндэтгэн тэмдэглэж байна.

**Н. Бадамханд**